

ЗҮҮН ХОЙД АЗИД АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН ТАЛТ МЕХАНИЗМ БҮРЭЛДЭХ БОЛОМЖ БА МОНГОЛ УЛС

А.Түвшинтөгс*

Хүйтэн дайн төгсгөл болсноор хүн төрөлхтний хүсэн хүлээсэн энх амгалан байдал тогтоогүйгээр барахгүй улс хоорондын болон иргэний дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг уламжлалт аюулаас гадна байгаль орчны гамшиг сүйрэл, халдварт өвчин, терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг уламжлалт бус аюул занал улс орон, бүс нутаг, дэлхий дахинд хор хохирол учруулсаар ХХI дүгээр зуунтай золголоо. Иймээс ч аюулгүй байдлын үзэл баримтлалаа эргэн харж, дэлхий нийтийн өмнө тулгарч буй нийтлэг аюул, сорилтын эсрэг хөгжилд суурилсан, хамтын аюулгүй байдлын тогтолцоо байгуулахыг НҮБ дэлхийн улс орнуудад уриаллаа.¹

Европ тивийн улс орнууд нийтийг хамарсан аюул, сорилтын эсрэг эвлэлдэн нэгдэж Европын Холбоо, НАТО, Европын зөвлөл, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) зэрэг олон талт механизмын хүрээнд “хоршсон”, “хамтын хүчин чармайлтаар” хамтран шийдвэрлэхээр стратегиа боловсруулан, хэрэгжүүлж байна.

Ази Номхон далайн бүс нутаг (АНДБН)-т Европтой харьцуулахад илүү нэгдмэл цул биш ч гэсэн бүс нутаг, салбар бүс нутгийн хэмжээний төрөл бүрийн интеграцийн процесс Азийн “өвөрмөц” онцлог шинжийг агуулан алгуур ч гэсэн урагшилж байна. Тухайлбал, аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөх АСЕАН-ий Бүсийн Чуулган, болон АСЕАН, АСЕАН+1, АСЕАН+3, АРЕК зэрэг эдийн засгийн хамтын ажиллагаанд түлхүү анхаарсан механизм, түүнчлэн Хятад, Оросын санаачлагаар Төв Азид хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан бүс нутгийн бүгд найрамдах 4 улс нэгдсэн Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нэгэнт бүрдсэний зэрэгцээ Зүүн Азийн Хамтын Нийгэмлэг (ЗАХН) байгуулах асуудал ид өрнөж байна.

* БХЯ-ны ССХ-ийн дэд захирал, проф., доктор (Ph.D)

¹ A More Secure World: Our Shared Responsibility. Report of the High-level Panel on Threats, Challenges and Change. United Nations, General Assembly. A/59/565.

Тэгвэл даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх болон олон улсын харилцааны шинэ дэг журмыг тодорхойлоход гол үүрэг, нөлөөтэй НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 3 гишүүн хаяа нийлдэг ЗХА-д “Хүйтэн дайн”-аас улбаалан үлдсэн Солонгосын хойг, Тайваний хоолойн урхаг голомтоос гадна газар нутгийн болон түүхийн холбогдолтой улс хоорондын харилцааны шийдэгдээгүй эмзэг асуудал хуримтлагдсан хэвээр байх уу? Бүс нутагт аюулгүй байдлын олон талт механизм байгуулахад юу саад болж байна вэ? Ерөөсөө механизм бүрдүүлэх нөхцөл боломж байна уу? Түүнийг бүрдүүлэхэд жижиг буурай орны үүрэг оролцоо, хэрэгтэй юу? Энэ мэт асуудал бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон аюулгүй байдал, олон улсын харилцааны мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд байж, олон эрдэмтэн судлаачид янз бүрийн санал, санаачлага дэвшүүлэн, хэлэлцэгдсээр байгаа билээ. Энэхүү илтгэлд дээрх асуултын заримд хувийн зүгээс судлаачийн байр сууринаас хариулт өгөхийг хичээлээ.

1. БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Солонгосын хойгийн асуудал. Хэдийгээр Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудал дайн гарч магадгүй бүс нутгийн хамгийн халуун цэг болсноороо уг асуудлыг энхийн аргаар, яриа хэлэлцээ, зөвшилцөөний журмаар шийдвэрлэхийн төлөө улс орнуудыг ойртон нягтруулж, цаашид аюулгүй байдлын асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлдэг байнгын механизм болж хөгжих үндэс суурь тавигдлаа хэмээн нилээд олон шинжээч үзэх болов. Гэхдээ сүүлийн 4 дэх удаагийн уулзалтаар хамтарсан мэдэгдлийн заалт бүрийг нарийвчлан тогтох нь цаашдын явцад чухал юм.²

Тайваны хоолойн асуудал. Тайванийн асуудлыг улс хоорондын гэхээсээ салан тусгаарлах үзэгдэлтэй холбож БНХАУ-ын дотоод аюулгүй байдлын хүрээнд тайлбарлах ёстой юм. Гэвч АНУ-ын оролцоотойгоор бий болсон, мөн ямар нэгэн хэлбэрээр АНУ-ын оролцоотойгоор шийдэгдэх магадлалтай тул улс хоорондын зөрчлийн тоонд оруулан үзэх шаардлагатай болно.

² Cossa A. Ralph. Six-party statement of principles: one small step for man. PacNet 41, September 19, 2005.

Их гүрнүүдийн стратегийн зөрчил

Хэдийгээр даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын гол гол асуудлаар нэгдмэл байр суурьтай ч нэг талаас, дэлхийн хэт их гүрний статусаа хэвээр хадгалахыг хичээсэн АНУ, нөгөө талаас олон туйлт тогтолцоог бүрдүүлэхийн төлөөх Орос, Хятадын байр суурийн ялгаа юм. Үүний илрэлийн сүүлийн жишээг ШХАБ-ын хүрээнд 2005 оны 7 дугаар сард болсон дээд хэмжээний уулзалт гаргасан хамтарсан мэдэгдэлдээ Төв Ази дахь Америкийн цэргийн баазын үргэлжлэх хугацааны асуудлыг тавьснаас харж болно.

Америк-Хятад. ЗХУ задарснаас хойш эдийн засаг болон улс төрийн дотоод асуудалдаа төвлөрсөн ОХУ-ын их гүрний байр суурь суларсан, их гүрний статусаа сэргээтэл нэлээд хугацаа шаардлагатайг харгалзан АНУ-ын хувьд шинэ зууны гол “стратегийн өрсөлдөгч”, “хамтран ажиллагч түнш” нь Хятад болсон.

Орос-Хятад. XXI дүгээр зуунд чиглэсэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлж буй хоёр гүрний хувьд бүс нутаг, олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах болон эдийн засгийн хувьд хамтран хөгжих талаар түншилж, глобал асуудлаар илт зөрчил үгүй хэдий ч бүс нутагт улс төрийн нөлөөгөө тогтоох, дэлхийн зах зээлд байр сууриа тогтоохын төлөө далд өрсөлдөөн байгаа ба цаашид Хятад хүчирхэгжих тусам ил гарах ч магадлалтай.

Хятад-Япон. 1990-ээд оны сүүлийн хагасаас Япон, Хятадын харилцаа шинэ үе шатанд гарсан. Шинэ үе шат гэдэг нь нэг талаар эдийн засгийн асуудлаар “харилцан түншлэх түшилцэх”, нөгөө талаар улс төрийн талаар “харилцан тэмцэлдэх” харилцаанд шилжиж, энэ нь улмаар Засгийн газар хоорондын харилцаанаас гадна ард түмний хоорондын харилцаанд нөлөөлж эхэлсэн юм.³ Ерөөсөө Японы хувьд Хятадтай харилцах харилцаа нэн чухал юм. 2002 оны 11 дүгээр сард Ерөнхий сайд Ж.Койзүмигийн “Гадаад харилцааны ажлын хэсэг”-ийн боловсруулсан “XXI дүгээр зууны Японы гадаад харилцааны үндсэн стратеги – шинэ үе шат, шинэ үзэл бодол, шинэ гадаад харилцаа” хэмээх баримт бичигт “Хятадтай яаж харьцах вэ гэдэг нь XXI дүгээр зууны эхэн үеийн Японы гадаад харилцааны хамгийн чухал сэдэв болоод байна”..., ... “хамтран ажиллах”, “харилцан оршин тогтнох”, “өрсөлдөх”, “зөрөлдөх” нь зэрэгцэн явагдах

³ Мори Казуко. Япон, Хятадын харилцааны шинэ үе шат болон Зүүн Ази. 2005 оны 7 дугаар сарын 05-нд Улаанбаатар хотод зохион байгуулсан Япон, Хятад, Монголын эрдэмтдийн семинар дээр тавьсан илтгэл.

“Хятадтай яаж харьцах вэ гэдэг нь XXI дүгээр зууны эхэн үеийн Японы гадаад харилцааны хамгийн чухал сэдэв болоод байна”..., ... “хамтран ажиллах”, “харилцан оршин тогтнох”, “өрсөлдөх”, “зөрөлдөх” нь зэрэгцэн явагдах хандлагатайг тодорхойлсон байна. Мөн “түүхийн хүлээсээс” гарч, ирээдүйдээ чиглэсэн бодлого явуулах нь чухал хэмээн дурьджээ.⁴

Газар нутгийн маргаан

Орос-Япон: “Хойд” хэмээх тодотголтой Курилын өмнөд хэсгийн 4 арлын талаар шийдэгдээгүй асуудал болон дайн дууссанаас хойш 60 жил өнгөрөөд байгаа ч хоёр улсын хооронд энхийн гэрээ байгуулаагүй зэрэг нь Орос-Японы хоорондын харилцааг шинэ шатанд гарах, үр дүнтэй хөгжүүлэхэд тушаа болсоор байна. Мөн Япон-Хятад, Япон-Өмнөд Солонгосын хоорондох маргаан нь ЗХА-д итгэлцлийг бэхжүүлэх, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төсөл хэрэгжүүлэхэд ч саад болж байгаа нь ойлгомжтой.

Түүхийн асуудлууд

Япон-Хятад, Япон-Өмнөд Солонгос: дэлхийн 2 дугаар дайнд Японы оролцоог зөвтгөсөн агуулгатай түүхийн сурах бичиг Японд гарсаар байгаа болон Японы цэргийн гэмт хэрэгтнүүдийн булш байрладаг Ясукуни сүмд Японы Ерөнхий сайд удаа дараа зочилж, мөргөлөг үйлддэг нь Солонгос-Японы, Хятад Японы харилцааг хурцатгасаар байгааг та бүхэн сайн мэднэ. Хятадын талаас Японтой харьцахад “Түүхийн асуудал” гэсэн хүчтэй хөзөр байсан бөгөөд тэр нь хүчинтэй байх тохиолдолд Японтой харьцах харилцаанд үргэлж давуу талтай байх “стратегийн үзэл бодол” давамгайлж ирсэн. Японтой харьцах харилцааг өмнө нь Хятадын коммунист нам болон Хятадын Засгийн Газар зохицуулдаг байсан бол одоо харин сэтгэлийн хөдлөлд ихээхэн автсан ард түмний хариултыг үл ойшоож боломгүй гэдгийг харуулж байна.

Ясукуни сүмд Ж.Койзүми 5 дахь удаагаа зочилсон нь Хятад, Өмнөд Солонгосын дургүйцлийг дахин хүргэж, хариуд нь дипломат алхам хийхэд хүргэсэн ба энэ байдал цаашид ч хэвээр байх төлөвтэй. Тухайлбал, Өмнөд

⁴ Basic Strategies for Japan's Foreign Policy in the 21st Century New Era, New Vision, New Diplomacy. November 28, 2002. Task Force on Foreign Relations for the Prime Minister. http://www.kantei.go.jp/foreign/policy/2002/1128tf_e.html

бэлтгэх яриа хэлэлцээ болох байсныг хойшлуулж буйгаа мэдэгдсэн байна. Өмнөд Солонгосын Гадаад хэргийн сайд Бан Ки Мун Ж.Коизуми Ясукуни сүмд мөргөдгөө даруй зогсоох ёстой хэмээн мэдэгдсэн юм. БНХАУ-ын Токио дахь элчин сайд Ж.Койзүмийн үйлдлийг ноцтой өдөөн хатгалга гэж нэрлэсэн бол, 10 дугаар сарын 23-нд Японы Гадаад хэргийн сайд Бээжинд айлчлах байсныг Хятадын эрх баригчид хүчингүй болгосон байна.⁵

Нөгөө талаар Японд ч Ерөнхий сайдын үйлдлийг Японы нийгэмд таашаахгүй хүмүүс нэлээд байдгийн зэрэгцээ Үндсэн хууль зөрчсөн үйлдэл гэж үздэг.

*On July 26, 2005, the Osaka High Court rejected an appeal filed by a 338-member class action suit of Japanese and Korean war-bereaved families seeking compensation for the prime Minister's visit to the Yasukuni Shrine on Aug. 13, 2001. The suit alleged that the Prime Minister's visit violated the principle of separation of church and state.*⁶

Батлан хамгаалах чадавхи, цэргийн зардлын өсөлт

ЗХА бүс нутаг нь дэлхийн хамгийн том армитай (1 саяаас дээш цэрэгтэй АНУ, ОХУ, БНХАУ, БНАСАУ) болон дэлхийд цэргийн зардлаараа тэргүүлдэг Америк, Орос, Хятад улс оршдог хамгийн цэрэгжсэн бүс нутаг юм. Хятад цэргийн бодит зардлаа 2-3 дахин багасгадаг хэмээн Америк шүүмжилдэг.⁷

Нөгөө талаар аюулгүй байдлын орчны үнэлгээ, батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчнийг шинэчлэх хөтөлбөртөө зарим улсыг аюултай хэмээн албан ёсны баримт бичигт тодорхойлсон нь цэргийн төсвөө өсгөх, батлан хамгаалах хүчээ зузаатгахад хүргэж байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, Өмнөд Солонгосын Батлан хамгаалах цагаан номд үндэсний аюулгүй байдалд аюул учруулж буй орны тоонд БНАСАУ-ыг нэрлэсэн⁸, Японы цэргийн аюулгүй байдалд Умард

⁵ Хятад, Өмнөд Солонгос хоёр Японтой харилцахаас татгалзлаа. "Зууны мэдээ" сонин. 2005 оны 10 дугаар сарын 19, №250 (2073).

⁶ James J. Przystup. Summer Calm. "Comparative Connections", A Quarterly E-Journal on East Asian Bilateral Relations. No. 3, 2005. pp. 13.

⁷ The Military Power of the People's Republic of China 2005. Annual Report to Congress. Office of the Secretary of Defense. p. 21.

⁸ Defense White Paper 2004. The Ministry of National Defense. The Republic of Korea. p. 332.

Солонгос болон Хятад улс аюул учруулж байгааг дурдсан нь итгэлцлийг бэхжүүлэхэд тодорхой хэмжээгээр саад тотгор болж байна.⁹

2. НААШТАЙ ХАНДЛАГУУД

Хэдийгээр бүс нутгийн улс хооронд дээр дурдсан хүндрэлтэй асуудлууд байгаа ч аюулгүй байдлын олон талт механизм бүрэлдэхэд дэм болох дараах хөрс дэвсгэр байна гэж үзэж байна.

Эдийн засгийн харилцан хамаарал. Тус бүс нутагт бүсчлэл эрчимжиж, улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарал тогтвортой өсч байна.¹⁰ Ерөнхийдөө АНДБН-т Хятад цөмтэй эдийн засгийн хамтын ажиллагаа бүрэлдэх төлөвтэй байна. Японы гадаад худалдааны нийт эргэлтэд Хятадын эзлэх хувийн жин нь экспортод 12.2 хувь буюу дэлхийд Америкийн дараа хоёрдугаар байр, импортод 19.7 хувь буюу нэгдүгээр байрт орж байна. Хятад улс БНСУ-ын хувьд 2002 онд нэгдүгээр хөрөнгө оруулалт байршигч улс, 2003 онд нэгдүгээр зэргийн экспортлогч, 2004 онд АНУ-ыг түрүүлэн худалдааны тэргүүн түнш болсон байна.¹¹ Умард Солонгос, Хятадын хоёр талын худалдаа 2004 онд 1,38 тэрбум долларт хүрчээ.¹² БНАСАУ, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа өсөхийн хэрээр Умард Солонгосын Хятадаас хамаарах хамаарал нэгэн адил нэмэгдэх хандлагатай байна.

Солонгосын хойгийн байдал. Хэдийгээр Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг тойрсон хамгийн сэтгэл түгшээсэн асуудал дээр төвлөрч байгаа ч уг асуудлыг нааштай шийдвэрлэхэд дэм болох харьцангуй таатай алхмууд сүүлийн үед ажиглагдаж байгаа нь ЗХА-ийн нөхцөл байдлыг өөдрөгөөр харах үндэс болж байна.

Юуны түрүүнд Солонгосын хойгийн цөмийн асуудлаарх 6 талт яриа хэлэлцээний 4 дэх удаагийн уулзалтаар уг асуудлыг шийдвэрлэх цаашдын үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон хамтарсан мэдэгдэл анх гаргасан нь олон

⁹ Defense of Japan 2004. "Inter Group Corporation", p.607.

¹⁰ Батчимэг М. Зүүн Азийн Интеграци ба Монгол Улсын оролцоо. "Стратеги Судлал", № 1, 2005. хуудас.

¹¹ Korea's Economy 2005. Korea Economic Institute and Korea Institute of International Economic Policy. Volume 21, 2005. p.43.

¹² Korea's Economy 2005. Korea Economic Institute and Korea Institute of International Economic Policy. Volume 21, 2005. p.55.

талт яриа хэлэлцээ, харилцан буулт хийх, зөвшилцөл үр дүнтэй болох нь нотлогдлоо.¹³

Хоёр Солонгосын хоорондын харилцаа ч нилээд ахицтай байна. Солонгос хоорондын иргэдийн харилцан зочлох хэмжээ сүүлийн жилүүдэд байнга өсч 2004 онд анх удаа 20 мянга давсан байна. Тухайлбал, харилцан зочлогч иргэдийн тоо 2002 онд 13877, 2003 онд 16303, 2004 онд 26534 болж өсчээ.¹⁴ 2003 онд хоёр Солонгосын худалдааны эргэлтийн нийт хэмжээ 697.04 сая доллар болж, урьд оноос 3.8 хувь буурсан байна. Цэргийн харилцааны хувьд 2004 оны 5 дугаар сарын 26-нд анх удаа хоёр Солонгосын хооронд генерал цолтны түвшинд уулзалт хийсэн байна.¹⁵ Хоёр харилцааг сайжруулахад “Солонгосын хойг дахь энх тайвныг бэхжүүлэх, хоёр Солонгосын харилцан нөхсөн хөгжил цэцэглэлтийг тогтоох замаар Зүүн хойд Азийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах” зорилготой БНСУ-ын Ерөнхийлөгчийн засгийн газраас дэвшүүлсэн үндэсний хөгжлийн урт хугацааны, иж бүрэн стратеги дэм болж буйг тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү стратегийн үндсэн зарчим нь:

- 1/ зөрөлдөөнийг яриа хэлэлцээний аргаар шийдвэрлэх;
- 2/ харилцан ойлголцол, “шууд оролцогч талууд” зарчимд үндэслэлсэн олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэх;
- 3/ ард нийтийн хүсэл сонирхлыг илэрхийлсэн бодлого боловсруулах зорилготой аж.¹⁶

БНАСАУ-ын хувьд сүүлийн үед улс төр, эдийн засгийн хүрээнд илүү нээлттэй болох зарим алхмыг болгоомжтойгоор хийж байна. Тухайлбал, 1998-1999 онд Өрнөдийн хоёрхон улстай харилцаагаа сайжруулсан бол 2000 оноос хойш 21 улстай харилцаагаа хэвийн болгож, эдүгээ Европын Холбооны Франц, Эстониос бусад 23 улстай харилцаа хэвийн болжээ.¹⁷ Гадаадын иргэдэд нутаг дэвсгэртээ хувийн компани байгуулахыг зөвшөөрөх, цахилгаан хэрэглээ, усны болон бусад хэрэглээний үнэ, татварыг хямдруулснаар гадаадын хөрөнгө

¹³ Joint Statement of the Fourth Round of the Six-Party Talks.
http://english.people.com.cn/200509/21/eng20050921_209896.html

¹⁴ Peace and Prosperity. White paper on Korean Unification 2005. Ministry of Unification. Republic of Korea. p. 22.

¹⁵ Peace and Prosperity. White paper on Korean Unification 2005. Ministry of Unification. Republic of Korea. p. 32.

¹⁶ Peace and Prosperity. White paper on Korean Unification 2005. Ministry of Unification. Republic of Korea. p. 17.

¹⁷ Korea's Economy 2005. Korea Economic Institute and Korea Institute of International Economic Policy. Volume 21, 2005. p.56.

оруулагчдад хөрөнгө оруулах орчныг тодорхой хэмжээгээр сайжруулсан байна.¹⁸

Мөн тус улс түүхэндээ анх удаа энэ оны хавар өөрийн вэб хуудсаа нээсэн нь чамлахааргүй дэвшил гэж болно.¹⁹

Газар нутгийн маргааныг шийдвэрлэх эрмэлзэл. Газар нутгийн маргааныг шийдвэрлэх эрмэлзэл холбогдогч улсуудын хувьд аажмаар буй болж, үлгэр дуурайл болохоор загвар үүсч байгаа нь сайшаалтай. Үүнд БНХАУ ОХУ-тай, Төв Азийн шинэ тулгар БНУ-уудтай хилийн асуудлаа бүрэн шийдвэрлэсэн туршлагыг бусад улсууд, ялангуяа Орос-Японы маргааныг шийдвэрлэхэд ашиглах боломжтой гэж үзэж байна.²⁰ Мөн Хятад-Японы хоорондын асуудлыг харилцан хүлээн зөвшөөрч бүрэн нөхцөл бүрэлдсэн үед эцэслэн шийдвэрлэхээр тогтсон зэрэг нь бүс нутгийн хэмжээнд туршлага болж байна.

Аюулгүй байдал, батлан хамгаалахын харилцаа, хамтын ажиллагаа, яриа хэлэлцээ. Бүс нутагт АНУ-тай тогтоосон гэрээт холбоотны хоёр талын уламжлалт харилцаанаас гадна батлан хамгаалах салбарын хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд ихээхэн хөгжлөө. Энэ нь батлан хамгаалахын сайд нарын харилцан айлчлал, стратеги зөвлөлдөх уулзалтаас эхлээд дунд тушаалтны уулзалт, төрийн цэргийн удирдлага, цэргийн тойрог, флотын харилцан айлчлал, эрдэм шинжилгээний хүрээлэн хоорондын харилцаа, цэргийн хамтарсан сургууль хүртэл өргөн хүрээг хамарч байна. “Хүйтэн дайн”-ы үед АНУ-ОХУ, АНУ-БНХАУ, ОХУ-БНХАУ-ын хувьд мөрөөдөхийн ч аргагүй байсан энэхүү цэргийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа нь бүс нутгийн улс орнуудын харилцааг дулааруулах, хардах сэрдэх байдлыг багасгаж, хөрш зэргэлдээ орнууддаа харьцангуй урьдчилан таамаглах бололцоо олгох, нийтлэг аюул заналтай хамтран тэмцэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар бүс нутгийн нөлөө бүхий орнуудаас голлон зохион байгуулж буй олон улсыг хамарсан төрөл бүрийн сургалт семинар, бага хурал нь тухайн орны аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогыг илүү ойроос таньж мэдэх, олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын

¹⁸ Korea's Economy 2005. Korea Economic Institute and Korea Institute of International Economic Policy. Volume 21, 2005. p.55.

¹⁹ See URL: <http://www.kccckp.net/en>

²⁰ Акихиро Ивасита. Опыт российско-китайских пограничных переговоров: применим ли он к территориальному вопросу между Россией и Японией? В книге “Взгляд вне рамок старых проблем: опыт российско-китайского пограничного сотрудничества.” Ответственные редакторы А.Ивасита, Д.Кривцов. Slavic Research Center, Occasional Paper No. 6. Hokkaido University, June 2005, Sapporo. pp. 67-80.

тулгамдсан асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй харилцан солилцох таатай боломж олгож байгааг сайшаан тэмдэглэж байна. Зарим тоймтойг дурьдвал:

АНДАБСТ. АНУ-ын хавай мужийн Хонолулу хот дахь Ази, Номхон далайн аюулгүй байдлын судалгааны Төвд тогтмол зохион байгуулдаг сургалт нь бүс нутгийн орнуудын цэргийн болон энгийн мэргэжилтнүүдийн хооронд нөхөрсөг харьцаа тогтоон, итгэлцлийг бэхжүүлэхэд маш их ач холбогдолтой байдаг.

Шангри-Ла Диалог: Олон улсын Стратеги судлалын Лондонгийн хүрээлэнгээс Сингапурын засгийн газартай хамтран Сингапур улсын нийслэлд жил бүр зохион байгуулдаг “Шангри-Ла Диалог” нь Ази Номхон далайн бүс нутгийн батлан хамгаалахын сайд нарыг олон талын арга хэмжээний хүрээнд нэгтгэж, аюулгүй байдал, батлан хамгаалахын тулгамдсан асуудлууд, бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлаарх илэн далангүй яриа хэлэлцээ явуулдаг цорын ганц механизм²¹ болж байгаа тул бүс нутгийн орнууд төлөөлөгчдөө тогтмол оролцуулах нь зүйтэй юм.

Түүнээс гадна Японы Үндэсний Батлан хамгаалах судлалын Хүрээлэнгээс жил бүр зохион байгуулдаг “АНДБН-ийн аюулгүй байдал” бага хурал, БХЯ-ны “Токиогийн Батлан Хамгаалахын Чуулган”, Үндэсний Батлан Хамгаалахын Академийн “Цэргийн шинжлэх ухааны олон улсын семинар”²², БНХАУ-ын ХАЧА-ийн БХИС-иас жил бүр зохион байгуулдаг “Олон улсын аюулгүй байдлын Симпозиум” зэргийг дурьдах хэрэгтэй.

АРФ-ийн хүрээнд. Анх удаа 2004 оны 11 дүгээр сард Бээжин хотноо гишүүн орнуудын батлан хамгаалахын дэд сайд нарын түвшинд аюулгүй байдлын асуудлаар хийсэн бага хурал нь хардлагыг бууруулж, харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болсон.²³

АСЕАН цөмтэй Зүүн Азийн Хамтын Нийгэмлэг. Бүс нутгийн Өмнөд Солонгос, Хятад, Япон улсын нэгдэн байгуулсан “АСЕАН+3” механизм, түүнчлэн өнөө яригдаж буй ЗАХН-ийн том интеграцийн үйл явц нь ЗХА-д аюулгүй

²¹ Lee Hsien Loong, *Securing the Future for A New Asia. Keynote Address by Prime Minister of Singapore at the 4th International Institute of Strategic Studies “Asia Security Conference”*. 3 June, 2005.

²² *Overview of Japan's Defense Policy*. May 2005, Japan Defense Agency. p. 23-25.

²³ *China's military diplomacy in 2004: Foster an image of big power with frequent joint military exercises*. http://english.people.com.cn/200412/21/eng20041221_168166.html

байдлын олон талт механизм бүрэлдэхэд таатай суурь дэвсгэр болох нь дамжиггүй.

3. ЗАРИМ ХУВИЛБАРУУД

Ихэнх эрдэмтэд одоо байгаа хамтын батлан хамгаалалтын уян хатан бус тогтолцоог илүү интеграцчилагдсан бөгөөд дэвжин цэцэглэгч ЗХА-ийн хөгжлийн тусын тулд хамтын ажиллагаанд үндэслэсэн аюулгүй байдлын тогтолцоогоор халах ёстой гэж үзэж байна.

Бүс нутагт аюулгүй байдлын олон талт бүтэц, механизм байгуулсан олон туршлага байдгийг хөндөлгүйгээр бүс нутгийн зарим орны эрдэмтдийн дэвшүүлсэн зарим хувилбарын талаар санал бодлоо илэрхийлье.

6 талт яриа хэлэлцээнд үндэслэсэн механизм. Нэлээд эрдэмтэд Солонгосын хойгийн асуудлаарх өнөөгийн 6 талт яриа хэлэлцээний механизмд суурилсан бүс нутгийн аюулгүй байдлын байнгын механизм байгуулахыг санал болгодог. Тухайлбал, Америкийн судлаач Жозеф Керами цөөн тооны хэсэг бүлэг улс нэг асуудалд төвлөрөх нь ЗХА-ийн аюулгүй байдлын үр ашигтай дэглэмийг хөгжүүлэхэд шаардлагатай журам, байгууллага, хэрэгжүүлэх механизм бүрдүүлэхэд ач холбогдолтой²⁴ гэсэн бол Хятадын судлаач Панг Жонгуанг ЗХА дахь аюулгүй байдлын механизм нь дор дурдсан шинжтэй байна гэж тодорхойлжээ.²⁵ Үүнд: Хятад, түүнчлэн цөмийн санаархлаа орхисон Умард Солонгос хамрагдах; АНУ тэргүүтэй хоёр талын аюулгүй байдлын харилцаатай зэрэгцэн орших; Хятад-Америкийн хамтын, бүтээлч өнөөгийн харилцааны үүднээс; Тайваний асуудлыг оролцуулан бүс нутгийн аюулгүй байдлын бусад асуудлыг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх; бүс нутгийн хэмжээнд ирээдүйд хандсан аюулгүй байдлын хамтын нийгэмлэгийн үндэс суурь болох.

Хэрэв 6 талт яриа хэлэлцээ өнөөгийн саад бэрхшээлийг даван туулж бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны байнгын механизм болон хөгжиж, Монгол түүнд хамрагдах аваас Монгол улсын хувьд гадаад харилцааны илүү таатай нөхцөл бүрдэх юм.

²⁴ Joseph R. Cerami. "From the Six-Party Talks to a Northeast Asian Security Regime?: Cooperative Threat Reduction Strategies and Institutional Development". "Bush School Working Paper", No. 525. March 3, 2005. Bush School of Government and Public Service. (For the 2005 International Studies Association Annual Convention), Honolulu, Hawaii. p. 1.

²⁵ Pang Zhongying. Building a regional security Mechanism. pacNet No. 13 A, April 05, 2005.

байдлын олон талт механизм бүрэлдэхэд таатай суурь дэвсгэр болох нь дамжиггүй.

3. ЗАРИМ ХУВИЛБАРУУД

Ихэнх эрдэмтэд одоо байгаа хамтын батлан хамгаалалтын уян хатан бус тогтолцоог илүү интеграцчилагдсан бөгөөд дэвжин цэцэглэгч ЗХА-ийн хөгжлийн тусын тулд хамтын ажиллагаанд үндэслэсэн аюулгүй байдлын тогтолцоогоор халах ёстой гэж үзэж байна.

Бүс нутагт аюулгүй байдлын олон талт бүтэц, механизм байгуулсан олон туршлага байдгийг хөндөлгүйгээр бүс нутгийн зарим орны эрдэмтдийн дэвшүүлсэн зарим хувилбарын талаар санал бодлоо илэрхийлье.

6 талт яриа хэлэлцээнд үндэслэсэн механизм. Нэлээд эрдэмтэд Солонгосын хойгийн асуудлаарх өнөөгийн 6 талт яриа хэлэлцээний механизмд суурилсан бүс нутгийн аюулгүй байдлын байнгын механизм байгуулахыг санал болгодог. Тухайлбал, Америкийн судлаач Жозеф Керами цөөн тооны хэсэг бүлэг улс нэг асуудалд төвлөрөх нь ЗХА-ийн аюулгүй байдлын үр ашигтай дэглэмийг хөгжүүлэхэд шаардлагатай журам, байгууллага, хэрэгжүүлэх механизм бүрдүүлэхэд ач холбогдолтой²⁴ гэсэн бол Хятадын судлаач Панг Жонгуанг ЗХА дахь аюулгүй байдлын механизм нь дор дурдсан шинжтэй байна гэж тодорхойлжээ.²⁵ Үүнд: Хятад, түүнчлэн цөмийн санаархлаа орхисон Умард Солонгос хамрагдах; АНУ тэргүүтэй хоёр талын аюулгүй байдлын харилцаатай зэрэгцэн орших; Хятад-Америкийн хамтын, бүтээлч өнөөгийн харилцааны үүднээс; Тайваний асуудлыг оролцуулан бүс нутгийн аюулгүй байдлын бусад асуудлыг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх; бүс нутгийн хэмжээнд ирээдүйд хандсан аюулгүй байдлын хамтын нийгэмлэгийн үндэс суурь болох.

Хэрэв 6 талт яриа хэлэлцээ өнөөгийн саад бэрхшээлийг даван туулж бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны байнгын механизм болон хөгжиж, Монгол түүнд хамрагдах аваас Монгол улсын хувьд гадаад харилцааны илүү таатай нөхцөл бүрдэх юм.

²⁴ Joseph R. Cerami. "From the Six-Party Talks to a Northeast Asian Security Regime?: Cooperative Threat Reduction Strategies and Institutional Development". "Bush School Working Paper", No. 525. March 3, 2005. Bush School of Government and Public Service. (For the 2005 International Studies Association Annual Convention), Honolulu, Hawaii. p. 1.

²⁵ Pang Zhongying. Building a regional security Mechanism. pacNet No. 13 A, April 05, 2005.

Хамтын хөгжилд үндэслэсэн механизм: Оросын нэртэй эрдэмтэн В.Михеев хамтран хөгжих замаар аюулгүй байдлын бүтэц бүрдүүлэхээр дэвшүүлсэн онол²⁶ нь асуудлыг илүү өргөн хүрээтэй авч үзсэн байна. Түүний онолоор:

- Өнөө хүртэл шийдэж чадаагүй хоёр талын асуудлуудыг бүс нутагт эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн нэгдсэн орон зай үүсч, улмаар улс төрийн нэгдсэн орон зай байгуулах тухай асуудал эхэлтэл “хойш тавьж”, энэ нь “интеграцийн логик”-ийн дагуу “аяндаа” шийдвэрлэгдэх болно.
- Дотоодын асуудал нь интеграцийн процессын өнөөгийн болон маргаашийн шаардлагад нийцүүлэн үндэсний эдийн засгийн стратегийг нийцүүлэх замаар шийдэгдэнэ.

Үүнийг хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь хөрөнгө капитал, хөдөлмөр, газар, технологи зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлийг хамтран ашиглах замаар ЗХА-д олон талт интеграцчлагдсан хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой аж. Тэрээр үйлдвэрлэлийн хүчин зүйлийг хамтран ашиглахын тулд ЗХА-д чөлөөт худалдааны бүс байгуулах, хөрөнгө оруулалтын нэгдсэн журам тогтоох, мөнгөний холбоо байгуулж, улмаар бүс нутгийн хэмжээнд нэгдсэн валюттай болох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэгдсэн стандарттай болох, санхүүгийн байгууллагад хийх аудитын нэгдсэн тогтолцоо бий болгох, визийн дэглэмийг харилцан хүчингүй болгох, боловсрол, гадаад хэлний сургалтын тогтолцоог харилцан нийцүүлэх зэрэг арга хэмжээ авахыг санал болгосон байна.²⁷

ЗХА-ийн механизм бүрэлдэх процесст АНУ-ын улс төр, эдийн засгийн идэвхтэй оролцоо чухал болохыг онцолсон Михеевийн саналыг бүрэн дэмжиж байна. Нөгөө талаар газар зүйн хувьд түгжигдмэл, хөрш хоёр том эдийн засгаас ихээхэн хамааралтай манай улс зөвхөн зээл тусламж хүлээн авагчийн хувьд бус, харин хөдөлмөр, нөөц баялгаа хоршиж, хамтран ажиллагч орны хувьд ЗХА-ийн бусад орноос хөрөнгө оруулалт, техник, технологи, санхүүгийн туслалцаа авч, харилцан ашигтай хамтран ажиллах өргөн боломжтой болно.

²⁶ Mikheev Vasily. *Integration Motivation: Forming a Security Structure Through Co-development in Northeast Asia*. "Far Eastern Affairs.", No. 2, 2002. pp. 9-25.

²⁷ Mikheev Vasily. *Integration Motivation: Forming a Security Structure Through Co-development in Northeast Asia*. "Far Eastern Affairs.", No. 2, 2002. pp. 22.

ЗХА-ийн аюулгүй байдлын ирээдүйд бүрэлдэх механизм нь гадуурхан хязгаар тогтоох байдлаар бус, харин АНДБН, ялангуяа Зүүн Азийн хэмжээнд өрнөж буй төрөл бүрийн интеграцийн үйл явцтай илүү нээлттэй харилцаатай байх, түүнчлэн АНУ-тай тогтоосон аюулгүй байдал, батлан хамгаалахын хоёр талын тогтолцоотой бие биеэ дэмжих, харилцан нөхөх байдлаар зэрэгцэн орших нь ашигтай гэж үзэж байна.

4. МОНГОЛ УЛСЫН БОЛОМЖ БА СОРИЛТ

Даян дэлхийд энх тайван, аюулгүй орчин бүрдүүлэхэд зөвхөн дэлхийн хэмжээний болон тив, бүс нутгийн их гүрнүүд төдийгүй жижиг буурай улс орны хувь нэмэр чухал ач холбогдолтой болохыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга 2002 онд Монгол улсад хийсэн айлчлалынхаа үеэр УИХ-д хэлсэн үгэндээ чухалчилж байсан билээ.²⁸

Иймээс ч бид дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд нийгмийн бүхий л хүрээг хамарсан шинэчлэлийг эхлүүлсэн өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд зах зээлийн эдийн засагтай, улс төрийн ардчилсан тогтолцоог байгуулах зорилтын хүрээнд үндэсний ашиг сонирхлоо дээдэлсэн, олон тулгуурт, нээлттэй, идэвхтэй гадаад бодлого баримталж, шилжилтийн үеийн саад бэрхшээл, хүндрэлийг амжилттай давахын тулд бүс нутгийн улсуудаас улс төр, эдийн засгийн дэмжлэг авах талаар ЗХА-д илүү итгэл найдвар тавьж ирлээ. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын "... Бүс нутгийн интеграцид орох нөхцлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ"²⁹ гэсэн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэв.³⁰ Үүнд:

- Монгол улс 1998 онд АСЕАН-ы Бүсийн Чуулгад элссэнээс хойш түүний төрөл бүрийн түвшний үйл ажиллагаанд тогтмол оролцож ирсэн нь Монголын зүгээс АСЕАН-ы орнуудтай ойртох, Азид байр сууриа бэхжүүлэхэд чухал алхам болсон юм.

²⁸ Kofi Annan, UN Secretary-General, Address to the State Great Khural (Parliament) of Mongolia: "Small States in Era of Globalization", Ulaanbaatar, October 16, 2002.

²⁹ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал.

³⁰ Төмөрчулуун Г. Монгол Улс ба Зүүн Ази. 2005 оны 7 дугаар сарын 05-нд Улаанбаатар хотноо Монгол, Хятад, Япон улсын эрдэмтдийн "Зүүн Азийн интеграци: өнөөгийн байдал, хэтийн төлөв" сэдэвт бага хуралд тавьсан илтгэл.

- Монгол улс 2004 онд АСД (Asian Cooperation Dialogue - Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ")-нд нэгдэн орсон.
- 1991 онд Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Зөвлөл /ПЕКК/ -д элсэн орох хүсэлтээ гаргасан бөгөөд улмаар 1997 онд ПЕКК-ийн Үндэсний Хороо буюу МонПЕКК-ийг байгуулж, 2000 онд түүний хавсарга гишүүний статустай болсон. Өдгөө энэ статусыг жинхэнэ гишүүний статус болгох зорилт тавьж байгаа.
- Мөн Солонгосын хойгийн асуудлаарх 6 талт яриа хэлэлцээний албан бус суваг болох Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ (NEACD)-нд оролцохоор нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан боловч сүүлийн үед Хойд Солонгос энэ хэлэлцээнд оролцохгүй байгаагаас үүдэн манайхыг өнгөрсөн 4 дүгээр сард Сөүлд болсон уулзалтаар элсүүлэх асуудал хойшлогдсон. Хойд Солонгос 6 талт хэлэлцээнд эргэж оронгуут Монголыг энэхүү албан бус сувагт элсүүлнэ гэж Америкийн тал мэдэгдээд байгаа болно.
- Монгол улс 2003 онд АПЕК-т элсэх өргөдлөө гаргасан боловч 2007 он хүртэл моратори тогтоосон тул түүнд элсэх ажил зогсонги байдалд ороод байгаа болно.
- Монгол улс АСЕМД элсэх талаар мөн хөөцөлдөн ажиллаж байгаа бөгөөд энэ оны 5 дугаар сард Киотод болох Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар АСЕМ-ийн гишүүнчлэлийн асуудлыг ярьж холбогдох журмыг гаргахыг хүлээнэж байгаа.
- Энэ оны 7 дугаар сард АСЕАН-ы орнуудын хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээнд нэгдэн орсон³¹ бөгөөд цаашид АСЕАН+3 механизмд орохыг зорьж, хоёр талын хэмжээнд гишүүн орнуудаас дэмжлэг авч байна.
- НҮБ-ын ХХ-өөс санхүүждэг Түмэн голын төсөлд оролцож ирсэн.
- ЭСКАТО –ийн шугамаар зарим төсөлд тухайлбал Азийн авто сүлжээ.³²

³¹ Гадаад хэргийн сайд АРФ-ийн хуралд оролцов. "Гадаад харилцаа", Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол. №10 (164), 2005 оны 9 дүгээр сар. Хуудас 8.

³² Annan Kofi. Mongolian International Security and Nuclear Weapon Free Status.

- Үүний зэрэгцээ CSCAP, ЗХА-ийн эдийн засгийн асуудлаар жил бүр Японы Нийгатад болдог бага хурал зэрэг 2 дахь сувгийн үйл ажиллагаанд манайх тогтмол оролцож ирсэн.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд Монгол улсыг Зүүн Азийн интеграцид оролцуулах улс орны дотоод эдийн засгийн таатай нөхцөл алгуур бүрэлдэж байгааг хэлэх ёстой. 1993-2003 онд эдийн засгийн бодит өсөлт жилд дунджаар 3.3 хувьд хүрч, 2004 онд энэ үзүүлэлт 10.6 хувь болж өссөн. Инфляцийн түвшин 1995 онд 53.1 хувь байсан бол 1998-2003 онд жилд дунджаар 10.0 хувиас хэтрээгүй болно.

Цөмийн зэвсэггүй статус. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын (ҮАБ)-ын үзэл баримтлалын үзэл санааны дагуу тус улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлэх бодлогын хүрээнд 1992 онд цөмийн зэвсэггүй бүс болгон зарласнаас хойш бараг 13 жил, манай санаачлагыг олон улсын хамтын нийгэмлэг бүрэн дэмжиж, уг асуудлыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд тусгаж хэлэлцдэг болсноос хойш зургаан жил өнгөрлөө. Ерөнхий Ассамблей цөмийн зэвсгээс ангид байх манай өвөрмөц статусыг хүлээн зөвшөөрч, түүнийг цаашид бэхжүүлэхэд чиглэсэн тогтоол 3 удаа баталсны дээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга уг асуудлаар Ерөнхий Ассамблейд гурван удаа илтгэл оруулж хэлэлцүүлсэн билээ.

Нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгох асуудлыг манай улс анх 1992 онд санаачилснаас хойш өвөрмөц статусаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах талаар багагүй зүйлийг хийж амжуулсан билээ. Тухайлбал,

1. Цөмийн зэвсэгтэй таван гүрний 2000 оны баталгаа нь манай аюулгүй байдлыг улс төрийн түвшинд бэхжүүлсэн чухал алхам болсныг тухайн үед НҮБ хүлээн зөвшөөрч байв. Дээрх баталгааг авах зорилгоор 2000 оны 2 дугаар сард “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” Монгол улсын хуулийг УИХ батлан гаргасан юм.
2. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн 2000 оны Дурбаны, 2003 оны Куала Лумпурын бага хурлуудаасаа гаргасан мэдэгдэлд Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжиж байгаагаа илэрхийлж, түүнийг олон улсын эрх зүйн үндэстэй болгох нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх

дэглэмийг АНДБН-т бэхжүүлэх чухал арга хэмжээ болно гэж цохон тэмдэглэж байв.

3. Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах асуудлыг 2001 онд цөмийн зэвсэгтэй таван гүрэн, Монгол болон НҮБ-ын шинжээчдийн Саппоро хотноо болсон зөвлөлдөх уулзалтаар тусгайлан хэлэлцсэн статусыг хамтран тодорхойлж, олон улсын эрх зүйн үндэстэй болгон батлагаажуулах арга хэлбэрийн талаар тодорхой зөвлөмж гаргаж, нэг ёсондоо цаашид авах арга хэмжээг тодорхойлж өгсөн юм.

Саппорогийн зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс манай улс 2002 оны эхээр БНХАУ, ОХУ-д саналаа бичгээр өгч, түүнийг зарчмын хувьд зөвшөөрсөн хариуг тэднээс мөн оны 4, 7 дугаар сард тус тус авсан. Одоо цаашид гурван этгээдийн хэлэлцээг эхлүүлэх талаар ажиллаж байна.

Ерөнхий Ассамблейн 55/33S тоот тогтоол Монгол улсын олон улсын аюулгүй байдлыг хангах асуудлыг цөмийн зэвсэггүй статусаар хязгаарлалгүй эдийн засаг, экологийн эмзэг байдлын талаар судалгаа хийлгэж³³ байгаад бид талархаж байдаг.

НҮБ-ын ЭСА-нд оролцох талаар. Монгол Улсын ҮАБ-ыг улс төр, дипломатын аргаар хангахаас гадна НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд өөрт ногдсон үүргээ биелүүлэх зорилгоор НҮБ-ын ЭСА-нд идэвхтэй оролцох бодлого баримталж байна. Өнөөгийн байдлаар манай зэвсэгт хүчин НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох чадвар бүхий цэргийн баг 3, цэргийн мэргэжсэн ажиглагчид 20 гаруйтай болоод байна.³⁴ Өнгөрсөн хугацаанд Бүгд Найрамдах Конго Улс, Судан, Баруун Сахар зэрэг Африкийн 3 оронд НҮБ-аас хэрэгжүүлж буй 3 энхийн ажиллагаанд манай Зэвсэгт хүчинээс 18 цэргийн ажиглагчид оролцоод байна. Одоогийн байдлаар НҮБ-аас Сьерро Лион улсад хэрэгжүүлж буй энхийн ажиллагаанд 250 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн багийг оролцуулах талаар Монгол улсын төрийн холбогдох байгууллагууд шийдвэр гаргалаа. Цаашдаа Монгол улс НҮБ-ын далбаан дор энхийн ажиллагаануудад оролцох хүрээгээ

³³ *Economic and Ecological Vulnerabilities and Human Security in Mongolia. UNDP Mongolia, Ulaanbaatar 2005.*

³⁴ Чойжамц Я. Монгол Улс НҮБ-ын энхийг сацуулах ажиллагаанд оролцож эхэлсэн нь. Улаанбаатар хотноо зохион байгуулсан "НҮБ-ын 60 жил: НҮБ ба Монгол Улсын хамтын ажиллагаа" сэдэвт бага хуралд тавьсан уотгэл.

өргөжүүлэн, цэргийн албан хаагчдаас гадна иргэний цагдаа, энгийн ажиглагчид зэрэг бусад мэргэжлийн ажилтнуудыг дээрх ажиллагаанд оролцуулах замаар дэлхий дахины аюулгүй байдлыг хангах их үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулсаар байх бодлогыг баримталж байгаа юм. Монгол улсын ЭСА-ны чадавхийг нэмэгдүүлэхэд гадны туршлага, санхүүгийн болон бусад туслалцаа хэрэгтэй байгаа бөгөөд АНУ чадвартай мэргэжилтэн бэлтгэх, бусад техникийн талаар дэмжлэг үзүүлэхийг сайд Д.Рамсфелд өнгөрсөн сард Монгол улсад айлчлахдаа дахин нотолсон нь бидэнд их урам болж байна.

Энэ ялдамд Монгол улсын ардчилсан нийгмийн үндэс суурийг баттай байгуулсан бидний өнөөгийн амжилтыг БНАСАУ болон Төв Азийн улсуудад үлгэр болохуйц бөгөөд хуучин геополитикийн өвөрмөц байршлынхаа хувьд чухал үүрэг гүйцэтгэх боломжтойг үнэлж, шилжилтийн хүндрэлийг туулахад АНУ болон бусад улсын дэмжлэг туслалцаа хэрэгтэйг олны сонорт хүргэж байгаа эрдэмтэн найз С.Норперт талархлаа илэрхийлье.³⁵

Хоёр Солонгостой дипломат харилцаатай цөөхөн орны нэгийн хувьд Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэх, Умард Солонгосыг илүү нээлттэй болгоход Монгол Улс зуучлагч болж, өөрийн гэсэн хувь нэмэр оруулах бололцоотой гэж үзэж байна. Нэг жижиг жишээ дурдъя. 2005 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хотноо хоёр Солонгосын дээд хэмжээний уулзалтын 5 жилийн ойд зориулсан Монгол-Умард Солонгосын эрдэмтэн судлаачдын дугуй ширээний ярилцлагад БНАСАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид анх удаа оролцсон юм. Энэ нь хуучин ижил системтэй байсан улсын хувьд Монголыг сонирхох, харьцангуй нээлттэй болж буй илрэл гэж үзэх үндэстэй. Энд нэг шинэ зүйл ажиглагдсан нь нэрийн хуудсан дээрээ и-мейл хаягаа бичсэн Төлөөлөгчийн тэргүүн манай Хүрээлэнг өөрийн улсын ижил төстэй Хүрээлэнтэй холбоо тогтоож өгөхөд туслахыг амласан билээ. БНАСАУ-ын эрдэмтэдтэй хоёр талын хамтарсан хурал, уулзалт, дугуй ширээний ярилцлага зохион байгуулж, санал бодлоо солилцох нь итгэлцлийг бэхжүүлэх, бодлогоо таниулах ихээхэн ач холбогдолтой байх болно.

³⁵ Steve Noerper. *Mongolia: Model for Transition Merits International Support. PacNet 42A, September 23, 2005.*

Энэ дашрамд ийм төрлийн арга хэмжээ зохион байгуулахад бидэнд санхүүгийн тусламж илүүдэхгүй гэдгийг та бүхэнд сонордуулъя.

ДҮГНЭЛТ

Бүс нутаг нь улс төр, нийгмийн тогтолцоо, түүх, соёлын их ялгаатайгаас гадна улс орны хооронд шийдвэрлэгдээгүй хуримтлагдсан асуудал нэлээд байгаагаас ЗХА-д аюулгүй байдлын байнгын механизм бүрэлдэх явц амаргүй бөгөөд ихээхэн хугацаа шаардах нь ойлгомжтой. Гэхдээ эдүгээ энэхүү механизм бүрэлдэхэд дэм болох Зүүн Азийн интеграцийн үйл явц, эдийн засгийн харилцан хамаарал, маргаантай асуудлыг зөвшилцөл, яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх хандлага давамгайлах болсон зэрэг урьдчилсан таатай нөхцөл бүрдээд байна. Иймээс уг хүрсэн түвшнийг зогсоох, бууруулах бус, хөгжүүлэхэд бүс нутгийн нөлөө бүхий улсууд илүү үүрэг хариуцлагатай хандах шаардлагатай байна.

Монгол улсын хувьд Зүүн Азийн интеграц, ЗХА-д аюулгүй байдлын байнгын ажиллагаатай механизм байгуулахыг талархан дэмжихээс гадна түүнд нэгдэн орсон, гишүүн байхыг эрмэлзэж байгаа. Улс төрийн ардчилсан тогтолцоотой, эдийн засгийн зах зээлийн харилцаатай, энхийг эрхэмлэсэн, хөгжилтэй, чинээлэг Монгол улс байх нь ЗХА-ийн хөгжил, аюулгүй байдлын ашиг сонирхолд бүрэн нийцнэ гэж үзэж байна.